

## ОХУ, МОНГОЛ, ХЯТАДЫН ЭДИЙН ЗАСГИЙН КОРИДОРЫГ БАЙГУУЛАХ НЬ

*Б.Санжмятав\**

***Abstract:** The China-Mongolia-Russia economic corridor is one of the 6 economic corridors, planned by Chinese initiative “Belt and Road”. From South-East Asia to Eastern Europe and Africa, Belt and Road initiative includes near 80 countries that account for half the world’s population and a quarter of global GDP. The article provides the major issues the of building the China-Mongolia-Russia economic corridor; his mechanism of cooperation, actions, taking by 3 countries.*

***Key words:** Economic Corridor, China-Mongolia-Russia*

\*\*\*

Хятад-Монгол-ОХУ-ын эдийн засгийн коридор бий болгох саналыг Хятадын ГХ-ийн сайд Ван И 2015 оны 4 дүгээр сарын 2-нд МУ-ын ГХ-ийн сайд Пүрэвсүрэнг Бээжинд хүлээн авах үеэрээ анх дэвшүүлжээ. Тэрээр гурван орны эдийн засгийн коридорын ач холбогдлыг үнэлж хэлэхдээ, “энэхүү коридорыг байгуулах нь гурван ард түмний амьдралд ач тусыг, гурван орны эдийн засагт хөгжлийг, Евразийн хөгжилд шинэ хүчтэй эрч хүчийг авчрах болно. Орос, Хятад, Монголын хооронд хөгжлийн хамтын ажиллагааны томоохон орон зай бий”<sup>1</sup> гэжээ

Гурван орны эдийн засгийн коридорыг байгуулах санал нь Хятадын дарга Ши Жиньпинээс 2013 онд дэвшүүлсэн “Бүс ба Зам” санаачилгын хүрээнд байгуулах 6 эдийн засгийн коридорын нэг нь болно.

Гурван орны хооронд эдийн засгийн коридорыг байгуулах нь орон тус бүрийн эдийн засгийн хөгжилд, мөн бүс нутгийн худалдаа, эдийн засгийн интеграцийг гүнзгийрүүлэхэд томоохон хувь нэмрийг оруулж чадах юм. Өнөөдөр дэлхий ертөнц бүхлээрээ хурдацтай хувьсан өөрчлөгдөж, түүний дотор дэлхийн эдийн засаг, шинжлэх ухаан урьд өмнө байгаагүйгээр түргэн хөгжиж байгаа тул цаг хугацаа туйлын үнэтэй болсон байна. Энэ боломжийг алдвал улс үндэстний хувь заяанд ч сөргөөр нөлөөлөх улбаатай байгаа болно.

Хятадын албан ёсны тайлбараар, “Бүс ба Зам” санаачилгын зорилго нь Хятадын зүгээс дэлхийн хэмжээнд даяарчлал, нээлттэй хамтын ажиллагаа, интеграцчиллыг дэмжих, Еврази, Африкийн орнуудын хооронд connectivity буюу холбоо харилцааг сайжруулах замаар эдийн засгийн хөгжилд хувь нэмрээ оруулах явдал гэж тодорхойлсон. Энэхүү санаачилга нь дотроо Ази, Европыг холбох “Нэг бүс, Нэг зам”, Ази, Европ, Африкийг холбох “XXI зууны далайн зам” гэсэн хэсгүүдээс

\* Олон улсын эдийн засгийн ухааны доктор, МУИС-ийн зөвлөх профессор

<sup>1</sup> РИА новости, 2015.04.02

бүрдэлдэж байна. Санаачилгын хүрээнд Ази, Европ, Африкийг эхний ээлжинд тээвэр, эрчим хүч, холбоо харилцааны дэд бүтцээр холбох, энд интеграцийн төслүүд хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

### **Нэг. Гурван талт хамтын ажиллагаа**

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн санаачилгаар 2011 оны 9 дүгээр сард ОХУ-Монгол-Хятадын гурван талт дээд хэмжээний уулзалтыг Душанбед ШХАБ-ын гишүүн орнуудын дээд хэмжээний уулзалтын үеэр анх удаа зохион байгуулсан нь гурван орны хамтын ажиллагааны механизмын үндэс суурь болсон байдаг. Гурван талт хамтын ажиллагаа нь Монгол Улсын хувьд нэн чухал үүрэгтэй.

Монгол Улс нь зөвхөн 2 хөрштэй, далайд гарцгүй орон боловч газар зүйн байрлалын хувьд дэлхийн хамгийн эрчимтэй хөгжиж байгаа хоёр томоохон зах зээлийн дунд орших учир дэлхийд өөр хаана ч байхгүй давуу талыг бодлогоор бий болгон ашиглах бололцоотой байгаа юм.

### ***Гурван талт хамтын ажиллагааны улс төрийн таатай нөхцөл***

Хөрш гурван орон түүхийн явцад хил залган оршиж, хүнд үеүүдэд бие биеэ дэмжиж ирсэн баялаг түүхтэй, орчин үед маргаантай ямар нэгэн асуудалгүй, найрамдалт харилцаа, худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны үндсэн зарчмуудыг гэрээ, хэлэлцээрээр баталгаажуулсан байх нь тэдгээр орнуудын хооронд улс төрийн дулаан уур амьсгалыг бүрэлдүүлж байдаг.

Монгол Улсын 2010 онд УИХ-аар батлагдсан гадаад бодлогын үзэл баримтлалын 14.1-д “ОХУ, БНХАУ-тай найрсаг харилцаатай байх нь Монгол Улсын гадаад харилцааны бодлогын эн тэргүүний зорилт мөн бөгөөд тэдгээр улстай бүхэлдээ тэнцвэртэй харилцаж, сайн хөршийн ёсоор өргөн хүрээтэй хамтын ажиллагаа хөгжүүлнэ” гэж онцолсон байдаг. Ийнхүү Монгол Улсын хувьд хөршүүдтэйгээ хамтран ажиллах нь гадаад бодлого, хамтын ажиллагааны тэргүүлэх чиглэл болж байгааг хуульчилж өгсөн билээ.

ОХУ нь өрнөдийн орнуудын зүгээс тавьсан хориг арга хэмжээтэй тулгарснаас хойш Ази, Алс Дорнодод хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхэд анхаарч байна. ОХУ энэ бодлогынхоо хүрээнд Монгол Улстай ч XXI зуун гарсаар найрсаг, уламжалт харилцааг өргөжүүлэн хөгжүүлэхэд анхаарч эхэлсэн. ОХУ-ын 2013 онд батлагдсан Гадаад бодлогын үзэл баримтлалын 86-д “ОХУ нь Монголтой уламжлалт, найрамдалт харилцаа холбоогоо цаашид бэхжүүлэх бодолтой” байна гэсэн тусгай заалт оруулж өгсөн байдаг. ОХУ-ын Төрийн Думын дарга Сергей Нарышкин 2015 оны 2 дугаар сард Монголд хийсэн айлчлалынхаа үеэр “ОХУ нь найрамдалт Монгол Улстай стратегийн түншлэлийн харилцаагаа бэхжүүлэх нь ОХУ-ын гадаад бодлогын тэргүүлэх чиглэлийн нэг болж байна” гэж хэлжээ.

Ерөнхийлөгч В.В.Путин Монголд 2000 онд айлчилж, Улаанбаатарын Тунхаглалыг баталсан нь энэхүү харилцааны шинэ үеийг нээсэн. Дараа нь ОХУ-ын Ерөнхийлөгч Д.Медведевийн 2009 оны 9 дүгээр сард хийсэн айлчлалын үеэр

монгол, оросын харилцааг стратегийн түвшинд гаргаж, Тунхаглал гаргасан.

Хятадын дарга Ши Жиньпин 2014 оны 8 дугаар сард Монголд айлчлах үеэрээ “... Хоёр тал Хятад, Монголын харилцааг иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааны түвшинд хүргэн дээшлүүлээ. ...Хятад, Монголын харилцааны ирээдүйд итгэл төгс байна. Хятад улс Монгол Улсыг оролцуулаад хөрш орнууддаа хөгжлийн боломж, хөгжих орон зайг олгоно” гэж хэлсэн байдаг. Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдоржоос 2015 онд БНХАУ-д хийсэн айлчлалын үеэр талууд “Монгол Улс, БНХАУ-ын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр”-ийн хүрээнд хоёр улсын худалдаа, эдийн засгийн бодит хамтын ажиллагааг нэмэгдүүлж, худалдааны бүтцийг сайжруулж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зэрэг чиглэлээр нягт хамтран ажиллаж, улмаар худалдааны хэмжээг 2020 онд 10 тэрбум ам.долларт хүргэх зорилтыг хэрэгжүүлэхээр тохиролцжээ.

Гурван талт хамтын ажиллагааны ач холбогдлыг төрийн тэргүүн нар дараах байдлаар үнэлжээ<sup>2</sup>. МУ-ын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж “урьд өмнө болж байгаагүй түүхт уулзалт болов”, БНХАУ-ын дарга Си Зиньпин “3 талт уулзалтыг зохион байгуулснаараа улс төрийн хувьд 3 орон хөрш улсууд байж, нэг хувь заяатайгаа ухаарч итгэлцлийг бэхжүүлэн ажиллах, эдийн засгийн хувьд 3 орны стратегийн зорилтуудыг хооронд нь уялдуулах, улмаар бүс нутгийн хамтын ажиллагааг гүнзгийрүүлэхэд ач холбогдолтой болно”, В.В.Путин “3 талт хамтын ажиллагааг хөгжүүлэх талаар бидний ярьсан зүйлүүд чухал ач холбогдолтой, хэрэгжих бололцоотой” гэж дүгнэжээ.

Гурван талт хамтын ажиллагааны үндсэн чиглэл бол эдийн засгийн хамтын ажиллагаа болохыг төрийн тэргүүн нараас тодорхой зааж өгсөн байна. Тухайлбал, МУ-ын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж “гурван орны улс төрийн харилцааны нэн таатай харилцааг эдийн засгийн агуулгаар баяжуулах нь талуудын ашиг сонирхолд бүрэн нийцнэ”<sup>3</sup>, БНХАУ-ын дарга Си Зиньпин “гурван талт хамтын ажиллагааны тэргүүлэх чиглэл бол эдийн засгийн хамтын ажиллагаа байх, гурван орон хөгжлийн стратегиа уялдуулах хэрэгтэй бөгөөд эл хамтын ажиллагаа нь ЗХА-д интеграцийг гүнзгийрүүлэхэд чухал хувь нэмэр болно”<sup>4</sup>, В.В.Путин “газар зүйн хувьд хөрш байгаагийн хувьд дэд бүтэц, эрчим хүч, уул уурхайн салбарт урт хугацаанд хамтран ажиллахад таатай нөхцөл бүрдүүлэх болно”<sup>5</sup> гэж тодорхойлжээ.

*Гурван талт хамтын ажиллагааг хөгжүүлэх олон улсын хүчин зүйлийн нөлөө*

XX зуунд эхэлсэн дэлхийн даяаршил зогсонги байдалд орж, улс орнууд бүс нутгийн хэмжээнд, түүний дотор Хятад, Монгол, Оросын хооронд худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны интеграцийг гүнзгийрүүлэхэд улам бүр ач холбогдол өгч байна. Энэ хүрээнд дараах хэдэн хүчин зүйлүүд улс орнуудын хамтын ажиллагаанд нөлөө үзүүлж байна. Үүнд *Дэлхийн эдийн засаг, бодлогын*

<sup>2</sup> Душанбегийн Орос, Монгол, Хятадын дээд хэмжээний уулзалт дээр ерөнхийлөгч нарын хэлсэн үг, 2011.09.


<sup>3</sup> Уфад 2015 онд болсон дээд хэмжээний уулзалт дээр хэлсэн үг, 2015.07.10

<sup>4</sup> Уфад дээд хэмжээний уулзалт дээр хэлсэн үг, 2015.07.10

<sup>5</sup> Мөн тэнд

төв Хойд Америк, Европоос Ази руу аажмаар шилжиж эхэлсэн. АНУ-ын Тагнуулын төв газрын дэргэдэх Судалгааны төв(National Intelligence Council)-өөс хийсэн судалгаагаар 2050 он гэхэд дэлхийн эдийн засаг дахь “Их Долоо”-гийн жин 20 гаруйхан хувь болж буурах бол, эрчимтэй хөгжиж буй 7 орны жин 50% болж өсөх төлөвтэй. Ингэхэд Хятад, Энэтхэг хоёр хамгийн том эдийн засгууд болох ба энэ үед ОХУ-ын эдийн засаг Японыхтой ойролцоо болох гэнэ. Энэ байдлыг дараах зурагт харуулав.

**Зураг 4 Дэлхийн томоохон бүлэг орны дэлхийн эдийн засагт эзлэх жин, 2016, 2050<sup>6</sup>**



Sources: IMF for 2016 estimate, PwC projections for 2050

G7 - Их долоо(АНУ, Герман, Франц, Итали, Испани, Япон, Их Британи) E7 - Эрчимтэй хөгжиж буй 7 орон (Хятад, Энэтхэг, Бразил, ОХУ, Өмнөд Африкийн БНУ, Мексик, Турк) Энэ нөхцөлд Монгол Улсын оршин буй Зүүн Ази, Еврази нь дэлхийн бодлого, эдийн засгийн цөм болон хувирах тул бид энэ бүс нутагтаа эртнээс өөрийн гэсэн байр суурийг эзэлж байх шаардлагатай байна.

- Аж үйлдвэрийн IV хувьсгал нь дэлхийн эдийн засгийг инноваци, робот техник, тоон технологийг нэвтрүүлж, программчлалаар удирдах, улмаар хангамж, үйлдвэрлэл, түгээлт, үйлчилгээний дэлхийн болон бүс нутгийн хэмжээний нэгдсэн сүлжээг үүсгэж байна. Хэрвээ бид бүс нутгийн эдгээр сүлжээнд нэгдэн хамрагдаж чадахгүй бол түүхий эд, бүтээгдэхүүн байлаа ч зарах бололцоогүй нөхцөл бүрдэхээр байна. Энэ нөхцөлд Монгол Улс нь хөрш орнуудтайгаа урт хугацаанд, харилцан биеэ нөхсөн, нэгдэн ажилладаг интеграцид орохыг шаардаж байна.

- Дэлхийн уур амьсгалын өөрчлөлт, хүн төрөлхтөний тулгамдсан нийтлэг асуудлууд, түүний дотор хоол хүнс, усны хангамж, байгалийн эрдэс баялгийн хомсдол зэрэг нь дэлхийн улс орнуудын зүгээс илүү ойр хамтран ажиллах, олон улсын стандартуудыг нийтээрээ мөрдөж ажиллах, үүсч буй нөхцөл, байдалд дасан зохицох, харилцан туслах шаардлагыг үүсгэж байна.

Эдгээр нөхцөл байдал нь улс орнуудын зүгээс дэлхийн хөгжлийн хандлагыг зөв тооцож, хөгжлийн стратегиа сонгож, хэрэгжүүлэх, бусад орнуудтай худалдаа,

<sup>6</sup> мөн тэнд, 6 дугаар тал

эдийн засгийн интеграцид хамтрах, нөөц баялаг, хөрөнгийн хуримтлалаа тооцоотой, үр ашигтай зарцуулах өндөр хариуцлагыг бий болгож, улс орны ирээдүйн хувь заяаг шийдвэрлэхээр байна. Энэ утгаар хүн төрөлхтөн өнөөдөр хөгжлийнхөө туйлын хариуцлагатай нэгэн үеийг эхлүүлж байгаа бөгөөд энд боломжийг сайтар ашиглах, алдаа гаргахгүй байж эрсдэлийг зөв тооцох асуудал туйлын чухал болоод байна. Энэ байдлыг ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путинаас ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путин “Дэлхий дахин өөрчлөлтийн, бүр эрч хүчтэй, далайцтай, томоохон өөрчлөлтийн шатанд явж байна. Хэрвээ бид чигээ зөв тодорхойлж, юу хийхээ, яаж хийх бодлогоо гарган, хэрэгжүүлж чадахгүй бол үүрд хоцрогдох эрсдэл байна”<sup>7</sup> гэж тодорхойлжээ. Эдгээр хүчин зүйлүүд нь Хятад, Монгол, Оросын гурван талт хамтын ажиллагааг гүйнзгийрүүлэн хөгжүүлэх таатай нөхцлийг бүрэлдүүлж байна.

### ***Хоёр. Хятад, Монгол, Оросын эдийн засгийн коридорыг байгуулах тохиролцоо, хэрэгжүүлж буй алхамууд***

ОХУ-Монгол-Хятадын гурван талт дээд хэмжээний 2015 оны Уфагийн уулзалтаар эдийн засгийн коридорыг байгуулах талаар зарчмын хувьд тохиролцож, 2016 оны Ташкентийн уулзалтаар эл хамтын ажиллагааны төлөвлөгөө буюу “замын зураг”-ийг баталж, эхний ээлжинд хэрэгжүүлэх 32 төслийг сонгож авсан төдийгүй хамтын ажиллагааны төслүүдийг боловсруулж, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэх зорилготой гурван орны “Хөрөнгө оруулалт, төлөвлөлтийн төв”-ийг Улаанбаатарт байгуулахаар тохиролцож, хамтын ажиллагааны асуудлыг хариуцан ажиллах гурван орны эрх бүхий байгууллагуудыг томилсон байна.

Гурван орны төрийн тэргүүн нарын хэмжээнд эдийн засгийн коридор байгуулах талаар хийсэн тохиролцоог хэрэгжүүлэх ажлыг холбогдох орнуудын Гадаад хэргийн дэд сайд, шинжээчдийн түвшинд уулзалтыг зохион байгуулж, хамтын ажиллагааг хөгжүүлэх асуудлуудыг авч хэлэлцэж байна.

Өнгөрсөн хугацаанд БНХАУ, Монгол, ОХУ-ын хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх, улмаар гурван орны эдийн засгийн коридорыг байгуулах чиглэлээр олон арга хэмжээг авч хэрэгжүүлээд байна. Тухайлбал:

- Гурван талт тээврийн хамтын ажиллагааны нэг чухал хэсэг бол Монгол Улсын далайд гарах бололцоог хангах явдал байлаа. Энэ ажлын хүрээнд МУ-аас Хятад, Оросын нутаг дэвсгэрээр дамжин далайд гарах, буцах, дамжин өнгөрөх тээвэр хийх тухай Монгол, Хятадын Засгийн газруудын, Монгол, ОХУ-ын Засгийн газруудын хэлэлцээрүүдийг шинэчлэн байгуулсан. Монгол Улсын зүгээс Улаанбаатар-Дарханы авто замыг 2019 онд шинэчлэн тавихаар шийдвэрлээд байна.

- ОХУ, Монгол Улс, БНХАУ-ын 2015 онд болсон тээврийн сайд нарын уулзалтаас 3 орныг холбосон авто зам, төмөр замын коридорыг хөгжүүлэх, одоо байгаа төмөр замыг шинэчлэх талаар тохиролцож, протоколд гарын үсэг зурсан.

<sup>7</sup> Речь В.В.Путина на съезде партии Единой России, 08.12.2018

-Монгол Улс, БНХАУ, ОХУ-ын Гаалийн газруудын хооронд хамтын ажиллагааны хэлэлцээр, Хилийн боомтын хөгжлийн салбарт хамтран ажиллах хэлэлцээрт гарын үсэг зуржээ.

- 2016 оны 9 дүгээр сард ОХУ-ын Улаан Үүдээс Улаанбаатараар дайран Хятадын Тяньжин хүрэх авто замын анхны туршилтын тээвэрлэлтийг хэрэгжүүлсэн.
- Монгол, ОХУ-ын иргэд 2015 оноос харилцан визгүй зорчих болсон.
- 3 орон аялал жуулчлалын салбарын хамтын ажиллагааны хүрээ болсон хэлэлцээрт гарын үсэг зурсан байна.
- Хятадын тал Монгол банк, Хятадын Төв банкны хоорондын мөнгөний СВАТ хэлэлцээрийн хэмжээг 10-аас 15 тэрбум юань болгож өсгөсөн.
- Замын Үүд, Эрээний хил дамнасан чөлөөт худалдааны бүсийг байгуулах талаар тохиролцож, одоо бэлтгэлийг хангаж байна.
- Монгол-Хятад-Оросын Худалдаа, аж үйлдвэрийн танхимуудын уулзалтыг 3 оронд ээлжлэн зохион байгуулж, талууд бүс нутагтаа хэрэгжүүлэхээр төлөвлөж буй төслүүдээ бизнесийн бүлгийнхэнд танилцуулж, үзэсгэлэн зохион байгуулах ажлууд хэвшээд байна. Эдгээр арга хэмжээнд оролцсон бизнесийн хүмүүс эхний ээлжинд аялал жуулчлал, хилийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, ажил хэргийн хүмүүсийн хоорондын мэлээллийн сүлжээг сайжруулах, бизнесийн таатай уур амьсгал бүрдүүлэхийн чухлыг онцлон тэмдэглэж байсан.

Энэ мэтээр гурван орны хамтын ажиллагааны хүрээнд, эдийн засгийн коридорыг байгуулах зорилгоор олон арга хэмжээг амжилттай хэрэгжүүлж чадсан болно. Гэвч эдгээр нь хурд, далайцын хувьд хангалттай биш байгаа тул энэ чиглэлийн үйл ажиллагаа, хамтын ажиллагааг эрчимжүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байгаа юм.

### **Гурав. Коридорыг байгуулахад үүсч буй бэрхшээл, шийдвэрлэх арга замууд**

Хятад, Монгол, Оросын эдийн засгийн коридорыг байгуулах ажил удаашралттай явж байгаагийн нэг үндсэн шалтгаан бол Монголын талын бодлого, үйл ажиллагаа тодорхойгүй байгаагаас болж байгааг хэлэх хэрэгтэй. Тухайлбал Монгол Улс бүс нутгийн худалдаа, эдийн засгийн интеграцид үндсэндээ нэгдэж чадаагүй<sup>8</sup>, хөрш орнуудтайгаа хөгжлийн бодлогоо уялдуулах, мөн хангамж, үйлдвэрлэл, түгээлт, үйлчилгээний сүлжээ үүсгэх талаар бодлогоо тодорхойлоогүй явж байна. Тухайлбал:

**Хөгжлийн стратеги.** Дэлхийн улс орнууд хөгжлийн стратеги боловсруулахдаа эхлээд өөрийн геополитик, геоэдийн засгийн давуу тал, эрсдэлийг судалдаг болжээ. Аливаа орны хөгжлийн стратеги нь холбогдох орны үндэстний язгуур эрх ашигт суурилж, тухайн орны хөрсөн дээр бууж байх ёстой болно. Тийм учраас улс орнууд хөгжлийн стратегиа сонгохдоо гаднаас хуулбарлах бус,

<sup>8</sup> Монгол Улс нь бүс нутгийн орнуудаас зөвхөн Японтой Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр байгуулсан боловч тэр нь Монголын эдийн засагт нааштай нөлөө үзүүлэхгүй төлөвтэй байгаа. БС



харин прагматик байж, өөрийн онцлогт тохируулан, үндэсний хөрснөөс ургуулан гаргаж ирдэг байна. Энэ утгаар Энтхэг улс хөгжлийн “Мамбэй зөвшилцөл”, Хятад “Бээжингийн зөвшилцөл”, БНСУ “Сөүлийн эдийн засгийн зөвшилцөл” загваруудыг боловсруулан хэрэгжүүлж байна.

Монгол Улс нь олон улсын валют, санхүүгийн байгууллагаас тулгасан “Вашингтоны тохиролцоо”<sup>9</sup>-ны дагуу төрөөс эдийн засгийг удирдах үүрэг оролцоог үгүйсгэсэн, урт хугацааны хэрэгжих үндэстэй, заавал биелүүлэх үүрэг бүхий төлөвлөгөөгүй, ялсан намын сонгуулийн 4 жилийн мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаж байгаа нөхцөлд хөрш орнуудад Монголтой хамтран ажиллахад амаргүй байдаг бололтой.

**Хөгжлийн бодлогын зохицуулалт.** Хөрш орнууд нь Монголын бодлогыг тодорхой болохыг хүлээх завсраа өөр хоорондоо хөгжлийн бодлогын зохицуулалтаа хийж, цаг үеийн хамтын ажиллагааны асуудлуудыг хамтран шийдэж, дотооддоо бэлтгэлээ хангаж байна. Тухайлбал, Хятадын төв Засгийн газар гурван талт хамтын ажиллагааг хөгжүүлэхэд Өвөр Монгол гол үүрэгтэй байхыг анхааран үзэж, эл хамтын ажиллагааг хөгжүүлэх бэлтгэлийг хангах зорилгоор улсын төсвөөс жил тутам тодорхой хэмжээний санхүүжилтийг гаргаж өгч байгаа ажээ<sup>10</sup>. Өвөр Монголын Засгийн газар дотооддоо замаа засч сайжруулах, зочид буудал барих, сургалт явуулах, хил гаалийн бүтцээ боловсронгуй болгох, хамтын ажиллагааны тодорхой төслийг санхүүжүүлж байна. Тухайлбал, Хятадад 2 удаа Монголын бүтээгдэхүүний томоохон үзэсгэлэнг зохион байгуулж, энэ үеэр монгол, хятадын ажил хэргийн хүмүүсийн хооронд гэрээ, хэлэлцээрт гарын үсэг зурах ажлыг зохион байгуулсан байна<sup>11</sup>.

ОХУ-аас Хятадтай эдийн засгийн хамтын ажиллагааны салбарт хийж байгаа томоохон тохиролцоонууд нь Оросын эдийн засгийн хөгжлийн ирээдүйн баталгаа болж байна гэж үзсэн<sup>12</sup> ба Хятадтай хөгжлийн бодлогоо уялдуулах ажиллагаа хэвшиж ирсэн байна. 2006 онд ОХУ-ын Ерөнхийлөгч Путинээс Хятадад хийсэн айлчлалын үеэр хоёр орны хамтын ажиллагааг урт хугацаанд төлөвлөн хэрэгжүүлэх, эхний ээлжинд ОХУ-аас газрын тос, байгалийн хий авах, тэдгээрийг хоолойгоор тээвэрлэх, санхүүжилтийн дийлэнх хэсгийг Хятадаас гаргах талаар тохиролцсон байдаг. Дээрх тохиролцооны дагуу ОХУ-аас Хятад руу газрын тос дамжуулах хоолой баригдаж ашиглалтад орсон бол, байгалийн хий дамжуулах хоолойн бүтээн байгуулалт төгсгөлийн шатандаа оржээ. Мөн Хятадын Зүүн хэсэг,

<sup>9</sup> “Вашингтоны тохиролцоо” хэмээх хөгжлийн загварыг ОУВС, ДБ-наас боловсруулж, хөгжиж буй орнуудтай хамтран ажиллахдаа урьдчилан нөхцөл болгон тавьж байсан. Энэ загварын дагуу төрийн эдийн засгийг удирдах оролцоог үгүйсгэж, төрийн өмчийг устгах, эдийн засаг, үнийг либералчлахыг шаарддаг. Гэвч энэхүү загвар нь онолын хувьд багтаагдаагүй, амьдрал дээр нааштай үр дүн өгөөгүй гэж 2008 оны 12 дугаар сард Вашингтонд болсон. “Их 20-ын бүлэг”-ийн анхны уулзалтаас дүгнэж, цаашдаа төрийн зохицуулалттай зах зээлийн эдийн засгийн загварыг баримтлахыг зөвлөсөн. БС

<sup>10</sup> AP ВНУТРЕННҮҮ МОНГОЛИҮ СОЗДАЕТ КИТАЙСКО-МОНГОЛЬСКО-РОССИЙСКИЙ ЭКОНОМИЧЕСКИЙ КОРИДОР, ГАЗЕТА “ЖЭНЬМИНЬ ЖИБАО” ОТ 16 МАҮ 2015, [HTTP://RUCHINA.ORG/MONGOL-ARTICLE/CHINA/787.HTML](http://RUCHINA.ORG/MONGOL-ARTICLE/CHINA/787.HTML)

<sup>11</sup> zhangyunbi, china daily, 2015.07.11

<sup>12</sup> ПоделиТЬсҮ... ОтношениҮ России и КитаҮ, [HTTP://EXPERT.RU](http://EXPERT.RU)

ОХУ-ын Алс Дорнод, Зүүн Сибирийг хөгжүүлэх хөгжлийн стратегиа уялдуулах, хамтран ажиллах талаар олон тохиролцоонуудыг байгуулжээ. Энэ хүрээнд Амур мөрөн дээгүүр гүүр, төмөр зам баригдаж ашиглалтад орсноор хоёр орны зүүн хэсгийн худалдаанд ачаа барааг төмөр замаар зөөх болсон. Баруун талаар Хятад, Оросыг холбосон төмөр замын хэд хэдэн маршрут нээгдэж, Казань-Москвагийн хурдны гал тэрэгний зам баригдаж эхэлсэн нь аажимдаа Бээжин хүрэх ажээ. Хоёр орны хамтын ажиллагааны төслүүдийг санхүүжүүлэх зорилготой ОХУ, Хятадын хөрөнгө оруулалтын банкиг ч байгуулжээ. Тус банкнаас санаачлан Амур мөрөн дээгүүр гүүр барих, Приморск боомтыг барих ажлыг санхүүжүүлсэн байна.

Хятадын дарга Ши Жиньпин, ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путин нарын 2015 оны 5 дугаар сард Москвад болсон уулзалтаар Хятадын “Бүс ба Зам” санаачилгын төслүүд, Евразийн эдийн засгийн холбооны бүтээн байгуулалтын ажлуудыг хооронд нь уялдуулж байх талаар тохиролцсон нь хоёр орны хөгжлийн бодлогыг уялдуулахад чухал нөлөө үзүүлж байна<sup>13</sup>.

**Гурван талт хамтын ажиллагааны механизм.** Эл хамтын ажиллагааны асуудлыг 3 орны төр, засгийн тэргүүн нарын уулзалтаар авч хэлэлцэн чиглэлийг гаргаж, энэ хооронд асуудлуудыг Гадаад хэргийн дэд сайд, шинжээчдийн хэмжээний уулзалтаар ярилцаж ирэв. Харин 2016 оны Ташкентийн уулзалтаар хамтын ажиллагааны төслүүдийг боловсруулж, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэх зорилготой “Хөрөнгө оруулалт, төлөвлөлтийн төв”-ийг Улаанбаатарт байгуулахаар тохиролцож, хамтын ажиллагааны асуудлыг хариуцан ажиллах гурван орны эрх бүхий байгууллагуудыг томилсон байна. Гурван орны хамтын ажиллагааны асуудлыг авч хэлэлцэн шийдвэрлэх үүрэгтэй бүтцүүд байгуулагдсан боловч бодит ажлууд удаашралтай явагдаж байгаа нь Монголын бодлого тодорхой болоогүй, хөрш орнууд нь хамтын ажиллагааны илүү том асуудлуудад тэргүүлэх ач холбогдол өгч байгаатай холбоотой гэж үзэх үндэстэй байна.

Өнгөрсөн хугацаанд талууд 2016 онд Ташкентын уулзалтаар тохиролцсон 32 төслөөс эхний ээлжинд 4 төслийг хэрэгжүүлэхээр сонгож, Уланбаатарт байгуулах “Хөрөнгө оруулалт, төлөвлөлтийн төв”-ийн эхлэл болгон монголын захирлыг томилон ажиллуулж эхлээд байна.

“Монгол-Орос-Хятадын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх гурван талын ажлын хэсгийн шинжээчдийн түвшний зөвлөлдөх уулзалтыг гурван орны нийслэлд ээлжлэн зохион байгуулж ирэв. Сүүлийн зөвлөлдөх уулзалт 2018 оны 12 дугаар сард Улаанбаатар хотноо болов. Эл уулзалтаас төмөр замын төв коридорыг үе шаттай шинэчлэн хөгжүүлэх техник, эдийн засгийн үндэслэлийг судлах хамтарсан ажлын хэсэг байгуулах, Азийн авто замын сүлжээгээр олон улсын авто тээвэр гүйцэтгэх тухай гурван улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн хэрэгжилтийг идэвхжүүлэх, Улаанбаатар хотноо гурван талын “Хөрөнгө оруулалт, төлөвлөлтийн төв” байгуулах ажлыг эрчимжүүлэхээр

<sup>13</sup> ОХУ-ын Гадаад хэргийн сайд Лавровын Уфад хийсэн хэвлэлийн бага хурал, 2015.07.09



тохиролцов. Түүнчлэн төмөр замын хойд коридорын Эрдэнэт – Овоот чиглэлийн төслийг хэрэгжүүлэх, Азийн автозамын сүлжээний АН-3 чиглэлийн дамжин өнгөрүүлэх замын чадавхийг нэмэгдүүлэх, эрчим хүчний салбарт хамтарсан төсөл хэрэгжүүлэх боломжийн талаар санал солилцсон байна.

## ДҮГНЭЛТ

Хятад, Монгол, Оросын гурван талт эдийн засгийн коридорыг байгуулахад ашгийн хамгийн бага хэсгийг Монгол хүртэхээр байгаа боловч Монгол Улсын эдийн засгийн хувьд нэн чухал ач холбогдолтой байх юм. Энэ талаар оросын эдийн засагч Денис Тетюшин “хятадын дээрх санаачилгыг хэрэгжүүлэх нь эдийн засгийн хувьд гол ашгийг мэдээж Хятад, тэгээд ОХУ хүртэх болно, харин Монгол нь санаачилгатай ажиллаж чадахгүй бол, тэдний дунд түнш л байх болно, харин геополитикийн хувьд хятадын эдийн засгийн хөгжлийг дэмжихэд ихээхэн хэрэгтэй байгаа Ази, Европыг холбох нэгэн зам(нөгөө зам нь Төв Азиар дамжин Хятад, Европ холбогдох болж буй) ашиглагдаж эхлэх, ОХУ-ын хувьд зам дагуу хөрөнгө оруулалт нэмэгдэх, Монголтой хамтын ажиллагааг идэвхжүүлэхэд хувь нэмрээ оруулах болно”<sup>14</sup>, Хятадын Нийгмийн ухааны Академийн ЗХА-ийн олон улсын харилцааны судлаач Zhong Felteng нь China Daily сонины сурвалжлагчид өгсөн ярилцлагадаа, Монгол нь бусад засгийн газруудаас, юуны өмнө ЕХ, Японы зүгээс стратегийн болон эдийн засгийн салбарт дэмжлэгийг авах гэж хичээсэн боловч зөвхөн хязгарлагдмал зарим амжилтад хүрсэн тул одоо Орос, Хятадтай илүү хамтран ажиллахад хүрсэн<sup>15</sup>, Хятадын хэвлэлд гарсан нэгэн өгүүлэлд, гурван талт хамтын ажиллагааны тухайд “Энэ удаад Хятад, ОХУ хоёр Монгол руу арай оройтож хандаж буй, Монгол бас муруй замаар явсан ч гэсэн Монголын хувьд үүнийг хүлээн авахгүй байж болохгүй бөгөөд аргагүйн эрхэнд хүртэх хамгийн сайн үр дүн юм”<sup>16</sup>, америкийн монгол судлаач А.Кэмпи бичихдээ, “Монголын хүчирхэг хоёр хөрш нь хоорондынхоо тээвэр, эрчим хүчний хамтын ажиллагааны асуудлыг тохиролцохдоо Монгол Улсын ашиг сонирхлыг харгалзан үзэхгүй явж ирснийг онцлоод, 3 талт хамтын ажиллагаа нь Монголын асуудалд анхаарах нөхцлийг бүрдүүлэх болно. Харин Монголоос хоёр хөрштэйгээ харилцах талаар баримталж байгаа бодлогыг евразийн бусад орнууд, бүр ЕХ, АНУ ч тэр бүр ойлгодоггүй”<sup>17</sup> гэжээ.

Үнэхээр ч НҮБ-ын Далайд гарцгүй орнуудын судалгааны төв (International Think Tank for LLDC), Японы судалгааны IDE-JETRO байгууллагаас хийсэн тооцоогоор Орос, Монгол, Хятадын гурван талт эдийн засгийн коридорыг байгуулбал жилд Монголд 482 саяам.долларын, Хятадад 4 682 сая ам. долларын, Оросод 518 сая ам.

<sup>14</sup> <http://expert.ru/2015/04/2/rossiya-pojdet-po-shelkovomu-puti-s-mongoliej/>

<sup>15</sup> Zhang Yunbi, SCO Extends Projects Cooperation Russia-China-Mongolia, China Daily, 2015.07.10

<sup>16</sup> \*Хятад, Орос гар нийлж ... Монголыг илбэн тохинуулна, 2016.05.2016 [www.junshi.xilu.com](http://www.junshi.xilu.com),

<sup>17</sup> mn \*Alicia Campi, Transforming Mongolia-Russia-China Relations: The Dushanbe Trilateral summit, 3 Nov. 2014, p

долларын ашиг өгнө гэж үзжээ<sup>18</sup>. Гэвч Орос, Монгол, Хятадын гурван талт эдийн засгийн коридорыг байгуулах нь Монголыг үйлдвэржүүлэх, зах зээлийг тэлэх, бүс нутгийн худалдаа, эдийн засгийн интеграцийн хүрээнд хөрш орнуудтайгаа хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх, хамтран хөгжих, бүс нутгийн хангамж, үйлдвэрлэл, түгээлт, үйлчилгээний сүлжээнд хамрагдахад нэн чухал үүрэг гүйцэтгэх болно. Ингэхийн тулд Монгол Улсын зүгээс бодлогоо тодорхойлж, коридорт байгуулах үйлдвэрүүдийн төсөл, тооцоог бэлтгэх, дэд бүтцээ холбох, хөгжүүлэх талаар илүү санаачлагатай ажиллах шаардлагатай байна.

### НОМ ЗҮЙ

1. Монгол Улсын Засгийн газрын Гурван тулгуурт бодлого, 2018,
2. Б.Санжмятав, Ө.Номинцэцэг, О.Цэрэнбазар, Ц.Батсугар, Д.Оргил, Саха Деван Мейанатан, “Бүс нутгийн эдийн засгийн интеграци: Монгол Улсын боломж ба эрсдэл” судалгаа, 2016
3. Б.Баасансүрэн, Орос, Хятадын завсар дахь Монгол Улс, УБ, 2019
4. Б.Санжмятав, Монгол Улсын эдийн засгийн гадаад хамтын ажиллагаа, УБ, 2019
5. B.Sanjmyatav, The Formation of Russia-Mongolia-China economic corridor relies on the trade and economic integration between the three countries
6. China-Mongolia-Russia Think Thank forum 2016, Huh Hot, Development Research Center of Inner Mongolia Autonomous Region,
7. B.Sanjmyatav, Most favorable direction of Mongolia in regional integration –Eurasian Economic Union, ERINA Report PLUS, 2018, June, n 142
8. Б.Санжмятав, Хятадын “Нэг бүс, нэг зам” санаачилга, түүний хэрэгжилт, МУИС-ийн Олон улсын харилцаа сэтгүүл, 2018,
9. Alicia Campi, Transforming Mongolia-Russia-China Relations: The Dushanbe Trilateral summit, 3 Nov. 2014
10. Economic Impacts of Economic Corridors in Mongolia, An Application of IDE-GSM, International Think Tank for LLDC, IDE – JETRO, 2017,
11. Орос, Монгол, Хятадын дээд хэмжээний Душанбегийн уулзалт дээр ерөнхийлөгч нарын хэлсэн үг, 2011.09
12. Орос, Монгол, Хятадын дээд хэмжээний Уфагийн уулзалт дээр хэлсэн үг, 2015.07.10
13. речь В.В.Путина на съезде партии Единой России, 08.12.2018
14. Внутренняя монголия создает китайско-монгольско-российский экономический коридор, газета “жэньминь жибао” от 16 мая 2015, <http://ruchina.org/mongol-article/china/787.html>
15. Zhang Yunbi, *SCO Extends Projects Cooperation Russia-China-Mongolia*, *China Daily*, 2015.07.10

<sup>18</sup> Economic Impacts of Economic Corridors in Mongolia, An Application of IDE-GSM, International Think Tank for LLDC, IDE – JETRO, 2017, p 15